



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ

**МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД**

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 51 02, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddic.gov.mn,
Цахим хуудас: www.mddic.gov.mn

2026-12-25 № 01/2954
танай _____-ны № _____-т

Хэрэгжилт хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1, 2, 3 дугаар хавсралтаар баталсан "Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам, Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-д тус тус заасны дагуу тус яаманд хамаарах "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн тайланг үүгээр хүргүүлж байна.

Тайланд холбогдох нотлох баримтуудыг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем www.unelgee.gov.mn -д оруулан баталгаажуулсан болно.

Хавсралт !!! хуудастай.



Э.БАТШУГАР

1525063280



**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМАНД
ХАМААРАХ 2025 ОНЫ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2025 он**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМАНД
ХАМААРАХ 2025 ОНЫ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
ТАЙЛАН**

2025.12.23

№

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний гол зорилго нь төрийн бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам” болон холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн акт заавар журмыг үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн 2025 оны эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дутуу гүйцэтгэлийг арилгуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд үндсэн зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар баталсан журмын “Хяналт-шинжилгээний арга зүй” болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.1-д заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнг тооцох аргачлалыг ашиглан хувиар илэрхийлсэн болно. Аргачлалд ашиглагдсан томъёог зургаар оруулав.

Зураг 1:

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} \cdot 100\%$$

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хамаарах 4 бодлогын хүрээнд туссан 8 ангиллын, 13 зорилгын 30 зорилт 46 төсөл, арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Мөн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 01/617 дугаартай албан бичгээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 2024 оноос 2028 оныг хүртэл хугацаанд хэрэгжүүлэх 10 зорилго, 24 зорилтын хүрээнд 69 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж илгээсэн болохыг дурдах нь зүйтэй байна.

2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хамаарах үндсэн арга хэмжээний 2025 оны биелэлтийн тайланг үндэслэн Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд ерөнхий гүйцэтгэл 48.14

хувьтай, өссөн дүнгээр 48.48 хувьтай, шалгуур үзүүлэлтийн хувьд бодлогын үнэлгээ 85.90 хувьтай, Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн 98.4 хувьтай, Хөтөлбөрийн үр дүн 99.7 хувьтай тус тус үнэлэгдлээ. 46 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хувиар задлан үзүүлбэл:

1. Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 85 хувь буюу түүнээс дээш "үр дүнтэй" хэрэгжсэн гэж үзэх 16 төсөл арга хэмжээ;
2. Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 60-84 хувь буюу "үр дүн хүлээгдэж байгаа" гэж үзэх 4 арга хэмжээ;
3. Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 30-59 хувь буюу "үр дүн хангалтгүй" гэж үзэх 5 арга хэмжээ;
4. Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 0-29 хувь буюу "үр дүн гараагүй" гэж үзэх 19 арга хэмжээ;
5. Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй буюу Х.Б тэмдэглэгээтэй 2 арга хэмжээ тус тус байна.

Түүнчлэн уг хөтөлбөр батлагдснаас хойш буюу 2025 оноос хэрэгжиж эхэлсэн байх тул бодлогын баримт бичгийн үр дүн хараахан гараагүй буюу суурь шатанд байна гэж үзлээ.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хамаарах бодлого, ангилал, зорилго, зорилт тус бүрийн биелэлтээр ерөнхий гүйцэтгэлийг дүгнэж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт1.Бодлогын үнэлгээ

№	Бодлого	Төсөл, арга хэмжээний тоо	Үнэлгээ
1	Бүсчилсэн хөгжлийн бодлого	3	33.33%
2	Хүний хөгжлийн бодлого	2	100.00%
3	Эдийн засгийн бодлого	2	0.00%
4	Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	39	50.47%

Хүснэгт2. Ангилал тус бүрийн үнэлгээ

Д/д	Ангилал	Төсөл, арга хэмжээний тоо	Үнэлгээ
1.2	Бие даасан эдийн засаг бүхий Улсын зэрэглэлтэй хот, дагуул хот	1	0.00%
1.4	Орон нутгийн хөгжил	2	50.00%
2.2	Эрдэм боловсролтой монгол хүн	2	100.00%
3.3	Эдийн засгийн төрөлжилт, либералчлал	2	0.00%
4.1	Хүний эрх, эрх чөлөө	3	33.33%
4.2	Авлигагүй засаглал	10	39.20%
4.3	Цахим засаглал, төрийн бүтээмжийн дахин инженерчлэл	24	59.42%
4.4	Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм	2	0.00%

Хүснэгт3. Зорилго тус бүрийн үнэлгээ

д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээний тоо	Үнэлгээ
1.2.2	Улсын зэрэглэлтэй болон дагуул хотуудын хөгжил	1	0.00%
1.4.2	Орон нутгийн хөгжлийн нийтлэг зорилт	2	50.00%
2.2.1	Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол	2	100.00%
3.3.2	Боомтын шинэчлэл, тээвэр, логистик	1	0.00%
3.3.7	Шинжлэх ухаан, технологи, инновац	1	0.00%
4.1.4	Ил тод байдал ба хяналт	1	100.00%
4.1.5	Шүүх засаглал	2	0.00%
4.2.2	Дэвшилтэт технологид суурилсан цахим засаглал	10	39.20%
4.3.1	"E-Mongolia"-блокчейн-Цахим засаглал	7	40.00%
4.3.2	Сансар судлал, харилцаа холбоо, мэдээлэл технологи	10	64.60%
4.3.3	Цахим орчин дахь хүний эрх, кибер аюулгүй байдал	7	71.43%
4.4.2	Гадаад бодлого	1	Х.Б

4.4.5	Эрсдэлийн удирдлага	1	0.00%
-------	---------------------	---	-------

Хүснэгт 4. Зорилт тус бүрийн үнэлгээ

Д/д	Зорилт	Төсөл, арга хэмжээний тоо	Үнэлгээ
1.2.2.5	Шинэ Зуунмод хот дахь чөлөөт бүсийг тулгуурлан "Цахиурын хөндий", дата төв, хүлэмжийн болон сэргээгдэх эрчим хүчний хосолсон загвар аж ахуйг хөгжүүлнэ.	1	0.00%
1.4.2.1	Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг дэмжинэ.	2	50.00%
2.2.1.1	Дижитал шилжилт, технологийн өөрчлөлт, шинэчлэлийн сорилтыг даван туулах чадвартай, монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох боловсролын үндэсний хөтөлбөрийг хөгжүүлнэ.	2	100.00%
3.3.2.22	Бүсүүдийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, тээвэр логистикийн сүлжээг сайжруулж, улсын болон орон нутгийн чанартай авто зам, төмөр замын дэд бүтцийг бүтээн байгуулж, боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	1	0.00%
3.3.7.4	Мэдээллийн технологи, судалгаа хөгжүүлэлт, инновацын үйл ажиллагаа эрхлэх татварын хөнгөлөлттэй чөлөөт бүс, шинжлэх ухааны паркийг хөгжүүлнэ.	1	0.00%
4.1.4.1	Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлж, төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.	1	100.00%
4.1.5.2	Шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмж, орчныг сайжруулж, хараат бус, бие даасан байдлын баталгааг нэмэгдүүлж, шүүгчийн мэргэжлийн ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлнэ.	1	0.00%
4.1.5.3	Шүүхийн процессыг цахимжуулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцыг ил тод болгож, хэрэг, маргааныг шуурхай, үр дүнтэй шийдвэрлэнэ.	1	0.00%
4.2.2.1	Төрийн үйлчилгээний шат дамжлагыг цөөн үе шаттай байхаар дахин инженерчлэл хийж, төрийн үйлчилгээг иргэнд шуурхай, чирэгдэлгүй хүргэнэ.	1	50.00%
4.2.2.2	Төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмжийг дээшлүүлж, иргэдэд түргэн шуурхай, хялбар үйлчилгээ үзүүлэх цахим төрийн тогтолцоонд шилжинэ.	2	50.00%
4.2.2.4	Төрийн тогтолцооны цахим дэд бүтцийг хөгжүүлж, шийдвэр гаргах үйл явцыг мэдэгдэхүйц хурдан, ил тод, нээлттэй болгоно.	7	34.57%
4.3.1.1	Төрийн бүх үйлчилгээг хиймэл юуны тусламжтайгаар хүсэлт шийдвэрлэх чадавх бүхий "Ухаалаг E-Mongolia" системийг хөгжүүлнэ.	1	100.00%
4.3.1.2	Үндэсний баялгийн сангийн нэгээс доошгүй хувийг инновац, технологийн салбарт зориулж, эдийн засгийн салбаруудын бүтээмж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.	1	50.00%
4.3.1.3	Мэдээлэл харилцаа холбоо, хиймэл оюун ухаан, шинэ технологийг уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, эрчим хүч, зам тээвэр, логистик, эрүүл мэнд, хөдөө аж ахуй болон бусад салбарт өргөнөөр нэвтрүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ.	2	15.00%
4.3.1.4	Төрөөс иргэн, бизнест үзүүлж байгаа үйлчилгээнүүдэд процессын шинжилгээ хийж бүрэн цахимжуулах, хиймэл оюун ухаан ашиглах, автоматжуулах боломжийг тодорхойлж, үйлчилгээ авах хугацаа болон үе шатыг 2 дахин бууруулна.	1	100.00%

4.3.1.5	Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, төрийн өмчийн бүртгэл, газрын хэвлийн баялаг болон газар дээрх баялгийн бүртгэлийг "блокчейн" технологийг ашиглан гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.	1	0.00%
4.3.1.6	Засгийн газрын тусгай сангуудын санхүүжилт, сонгон шалгаруулалтыг цахимжуулж ил тод болгоно.	1	0.00%
4.3.2.1	Үндэсний хиймэл дагуул хөөргөж, нам орбитын хиймэл дагуулын үйлчилгээ үзүүлэгчдийг дэмжинэ.	3	0.00%
4.3.2.2	Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг тэлэн орон нутагт өндөр хурдны интернэтийн сүлжээг хүртээмжтэй болгож, интернэтийн орон нутгийн тарифыг эрс бууруулж, Улаанбаатар хотын тарифтай ойртуулж төрийн үйлчилгээг цаг алдалгүй, шуурхай авах боломжийг бүрдүүлнэ.	3	94.33%
4.3.2.3	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих татварын хөнгөлөлттэй виртуал бүсийг байгуулж, "венч" зэрэг хөрөнгө оруулалтын тогтолцоог хөгжүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийтийн мэдээллийн системүүдийг хөгжүүлнэ.	2	100.00%
4.3.2.4	Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, үүлэн тооцоолуур, "блокчейн", юмсын интернетийг төрийн үйл ажиллагаа, үйлчилгээнд хэрэглэж болох чиглэлүүдийг тодорхойлох, судалгааны ажлуудыг санхүүжүүлэх, үе шаттай туршилтын төслүүдийг эхлүүлнэ. Төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжинэ.	1	80.00%
4.3.2.6	Дэлхийд өрсөлдөх чадвартай, технологийн тэргүүлэх байгууллагын сертификаттай 1,000 мэргэжилтэн бэлтгэж, 1,000 өндөр технологийн ажлын байр бий болгох үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.	1	83.00%
4.3.3.1	Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, мэдээллийн аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлого, зохистой хэрэглээний талаар хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	1	100.00%
4.3.3.2	Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг хэрэгжүүлнэ. Их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилсан кибер аюулгүй байдлын тогтолцоог олон улсын түвшинд хүргэн бэхжүүлнэ.	1	0.00%
4.3.3.3	Кибер аюулгүй байдлыг хамгаалах тогтолцоог олон улсын түвшинд хүргэн бэхжүүлж, төр, иргэний цахим мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах бодлого хэрэгжүүлнэ.	1	0.00%
4.3.3.4	Хувь хүний мэдээллийн аюулгүй байдал, цахим болон тоон гарын үсэг, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах цахим засаглалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	1	100.00%
4.3.3.5	Бүх салбарын цахим шилжилтийн үйл ажиллагааг интеграцлагдсан кибер аюулгүй байдлын тогтолцоогоор хангана. Үүний хүрээнд төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг улсын хэмжээнд өргөжүүлнэ.	1	100.00%
4.3.3.6	Кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцийг чадавхжуулж, бүх нийтийн кибер аюулгүй байдлын мэдлэг ойлголтыг дээшлүүлнэ.	2	100.00%
4.4.2.9	Олон улсын сансар судлалын хамтын судалгааны уулзвар цэг байх, хамтын ажиллагааны таатай орчин бүрдүүлэх бодлого баримтална.	1	X.6
4.4.5.3	Хамтрагч, түншлэгч талууд болон олон нийтэд мэдээллийг түргэн шуурхай хүргэх, солилцох нөхцөлийг бүрдүүлж, хамтын итгэлцлийг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлага, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх хүрээнд гадаад болон олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	1	0.00%

Засгийн газрын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн тайланд уншилт хийхэд хөтөлбөрийн "Эдийн засгийн бодлого" хэсэгт туссан Дэлхийн инновацын индексийг 1 байраар урагшлуулахаар буюу 68-аас 67 дугаар байранд эрэмбэлүүлэхээр төлөвлөсөн зорилтын биелэлтийг "Монгол Улс нь Дэлхийн инновацын индексээр 2023 онд 132 улсаас 68, 2024 он 67 дугаар байр, 2025 онд 78 дугаар байр эзэлсэн" гэж тайлагнасан тул зорилтот түвшинд бүрэн хүрээгүй гэж үзэж 85.90 хувиар үнэлгээ хийлээ.

Мөн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн бусад шалгуур үзүүлэлтийн үр дүнг дараах байдлаар үзүүлэв.

Д/д	ЗГҮАХ-ийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Үнэлгээ
Бодлого							
1.	Гурав. Эдийн засгийн бодлого	3.Дэлхийн инновацын индекс	Байр /эрэмбэ/	68/137 улсаас	67	78	85.90%
ТЕЗ-ийн үр дүн							
1	6. Дэлхийн гарааны бизнесийн экосистемийн индексийн үзүүлэлт сайжирсан байна.	1. Дэлхийн гарааны бизнесийн экосистемийн индекс	Эрэмбэ	81.00	80	78	100.00%
2	15. Шуудангийн хөгжлийн индексийн үзүүлэлт сайжирсан байна.	1. Шуудангийн хөгжлийн индекс	оноо	46.70	50	46.40	92.80%
3	48. Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн үзүүлэлт сайжирсан байна	1. Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн индекс	Оноо	87.00	88	88.40	100.00%
4	60. Цахим засаглалын хөгжлийн индексийн үзүүлэлт сайжирсан байна.	1. Цахим засаглалын хөгжлийн индекс	Эрэмбэ	46.00	46	46	100.00%
5	62. Кибер аюулгүй байдлын орчин сайжирсан байна.	1. Кибер аюулгүй байдлын индекс	Оноо	56.00	56	56.36	100.00%
Нийт үнэлгээний дундаж							98.4%
Хөтөлбөрийн үр дүн							
1	17. Дотоодын нийт бүтээгдэхүүнд мэдээллийн технологийн салбарын эзлэх хувь өссөн байна.	1. Мэдээллийн технологийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Хувь	0.12	0.15	2.42	100.00%
2	31. Улс хооронд болон хот хоорондын шуудан, илгээмжийн солилцооны тоо нэмэгдэнэ.	1. Илгээмж солилцоо	тоо	295885.00	300000	333372.00	100.00%
3	45. Иргэдийн цахим ур чадварын түвшин сайжирсан байна.	1. Иргэдийн цахим ур чадварын түвшин	Хувь	43.80	45	-	Х.Б
4	129. Төрийн үйлчилгээтэй холбоотой цаг хугацаа, орон зайнаас хамаарсан зардлыг бууруулна.	1. Иргэнээс гарах зардлын хэмнэлт	Тэрбум төгрөг	351.00	531	595.00	100.00%
5	134. Төрийн үйлчилгээнд хиймэл оюун	1. Хиймэл оюун ухааны бэлэн	Эрэмбэ	109.00	105	100.00	100.00%

	ухааныг нэвтрүүлнэ.	байдлын индекс					
6	135. Монгол Улсын хаанаас ч интернэтийн сүлжээнд холбогдох боломж бүрдсэн байна.	1. Интернэт хэрэглэгчид	Хувь	85.90	86.5	85.18	98.47%
7	137. Кибер орчинд төр, иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн аюулгүй байдал, нууцлал, хүртээмжийг хангана.	1. Олон улсын кибер аюулгүй байдлын индекс	Эрэмбэ	103.00	103	103.00	100.00%
8	138. Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.	1. Тоон гарын үсгийг нэвтрүүлсэн систем	Тоо	6.00	12	17.00	100.00%
Нийт үнэлгээний дундаж							99.7%

Дээрх хүснэгтүүдээс үзвэл Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны эцсийн байдлаарх гүйцэтгэл хангалтгүй байгаа боловч, салбарт хэрэгжүүлж буй бусад үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтүүд сайн үзүүлэлтүүдтэй байгааг илтгэн харуулж байна.

Иймээс Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын хүрээнд төлөвлөн гүйцэтгэж буй төсөл арга хэмжээтэй холбоотойгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжээс гаргасан дүгнэлт, зөвлөмжийг дор бэлтгэлээ.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн зорилтын хүрээнд туссан 46 төсөл, арга хэмжээний 13 төсөл, арга хэмжээ нь санхүүжилттэй холбон тайлагнасан байх бөгөөд 2025 оны төсвийн жилд Цахим хөгжил, инновац харилцаа холбооны яамнаас төсвийн төсөөлөлд хийж хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрийг багтаан илгээсэн гэх боловч, зарим төсөл, арга хэмжээ төсвийн тодотголоор хасагдсан, төсөв татагдсан гэх мэт шалтгаануудтай байгаагаас үүдэлтэй тухайн арга хэмжээ хэрэгжээгүй байх гол нөхцөл болжээ. Иймээс цаашид төсөв шаардлагатай зорилт, арга хэмжээг бодлогын баримт бичгийг хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд анхаарч, төсвийг зарцуулах хугацаа, хийгдэх ажиллагааг оновчтой төлөвлөх шаардлагатай байна.

Түүнчлэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17-д "бодлогын зорилт" гэж бодлогын зорилгод нийцсэн, улс, салбар, салбар хооронд болон бүс орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц, бодитой, хугацаатай эерэг өөрчлөлтийг, 4.1.22-т "шалгуур үзүүлэлт" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан тоон болон чанарын үзүүлэлтийг ойлгохоор заасан. Гэвч Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тайлагнаагүй, шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг оновчгүй тодорхойлсон асуудлууд ихтэй байснаас үнэлгээг хийхэд хүндрэл учирсан болно.

Өөрөөр хэлбэл бодлогын зорилтууд шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнагдсан бол тухайн бодлогыг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засгийн хөгжил, түүнчлэн эрх зүйн орчин болон засаглалын тогтолцоонд үзүүлсэн нөлөөний талаар хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан бичигдэхээр байлаа.

Тодруулбал арга хэмжээг хэрэгжүүлэхдээ буруу шалгуур үзүүлэлтийг тавьсны улмаас тайлагналт үр дүнрүү чиглээгүй байна.

Гэсэн хэдий ч хөтөлбөрийн хувьд амжилттай үр дүн гарсан гэж үзэж болох хэд хэдэн арга хэмжээ байна. Үүнд:

Бүсчилсэн хөгжлийн бодлогын 1.4-т Орон нутгийн хөгжил ангиллалд багтах 1.4.2-т заасан Орон нутгийн хөгжлийн нийтлэг зорилгын 1.4.2.1-д туссан “Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логиستيкийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг дэмжих” зорилтын 151-д туссан “Шуудангийн үндсэн сүлжээний тоног төхөөрөмжийг шинэчлэх, автоматжуулах” төсөл арга хэмжээний биелэлт хангалттай буюу Алслагдсан орон нутаг, сумын шуудангийн үйлчилгээний чанар, бүртгэл, хяналт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг сайжруулахад зайлшгүй шаардлагатай пос тоног төхөөрөмжийг Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр шийдвэрлэж, тэдгээрийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны “Хөрөнгө шилжүүлэх тухай” А/121 дүгээр тушаалаар “Монгол шуудан” ХК-д бүрэн хүлээлгэн өгсөн гэжээ. Энэ нь бүсчилсэн хөгжилд тодорхой хувь нэмэр болж буй үр дүнтэй арга хэмжээ болсон гэж үзэх үндэслэлтэй байна.

Хүний хөгжлийн бодлогын 2.2-т Эрдэм боловсролтой монгол хүн ангилалд багтах 2.2.1-д заасан Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол зорилгын 2.2.1.1-д. Дижитал шилжилт, технологийн өөрчлөлт, шинэчлэлийн сорилтыг даван туулах чадвартай, монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох боловсролын үндэсний хөтөлбөрийг хөгжүүлэх зорилтын 300-д “Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор иргэдэд ур чадвар олгох суурь сургалтыг зохион байгуулах” арга хэмжээний биелэлт амжилттай буюу “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны харьяа

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх, мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтийн цахим ур чадвар олгох V аяны хүрээнд сургалтыг үндэсний хэмжээнд 21 аймагт 105 удаа, 112 суманд 560 удаагийн сургалтыг зохион байгуулсан. 2025 онд нийт 48248 иргэнийг хамруулсан.

И-Монгол академи УТУГ-аас бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн суурь мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор иргэдэд цахим ур чадвар олгох суурь сургалтыг төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудтай хамтран танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулсан. 2025 оны байдлаар 63 удаагийн давтамжтай нийт 5008 иргэнийг хамруулсан.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТУГ-аас хүүхдүүдэд техник сэтгэлгээ, бүтээлч байдал, асуудал шийдвэрлэх чадварыг төлөвшүүлэх Код+Инженер сургалт, Өсвөрийн сансрын инженер сургалт, ШИМТ воркшоп, нийт 4 удаагийн арга хэмжээнд 48 суралцагчийг хамрагдсан.

“Бүтээлч иргэний дижитал шилжилт” сургалтын хүрээнд “Миний кодын эхлэл” хакатон тэмцээнийг 02 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд Өмнөговь аймгийн II сургуульд 30 хүүхэд, 11 дүгээр сарын 19, 20-ний өдрүүдэд Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 14 сургуулийн 9-11 дүгээр ангийн 27 сурагч хамрагдсан.

“DEV HACKATHON 2025” арга хэмжээ, Хакатон тэмцээнд 6 их дээд сургуулийн 94 оюутан, залуус; D-TECH YOUTH 2025 хөтөлбөрийн хүрээнд “Ур чадварын ялгааг арилгах нь” 55 оролцогч хамруулж, нийт 4 удаа 201 оролцогч хамруулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг сайжруулах зорилгоор “Аюулгүй цахим хэрэглээ” сургалтад 19, Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран “Сошиал маркетинг” сургалтад 4 суралцагч хамруулав. “Reel хэрхэн хийх вэ” сургалтад 4 суралцагч, “Хүртээмжтэй вэб сайт 2025” сургалтыг 4 удаа зохион байгуулж, 64 суралцагч хамруулав. Сургалтаар цахим орчин, вэбсайтын талаар мэдлэг ойлголттой болж, Web Content Accessibility Guidelines (WCAG) стандартыг Монгол Улсад

нутагшуулах талаар мэдлэг олгох сургалтад 122 суралцагч хамруулсан” гэж тайлагнажээ.

Цаашид уг арга хэмжээний төлөвлөгөө болон шалгуур үзүүлэлтийг зөвтгүүлэх шаардлагатай. Тодруулбал дээрх зорилтыг хэрэгжүүлэх шалгуур үзүүлэлтийг зохион байгуулсан арга хэмжээгээр илэрхийлэх бус гарсан үр дүнд чиглэх байдлаар төлөвлөх нь зүйтэй гэж үзэж байна. Жишээлбэл: Сургалт зохион байгуулсаан үүдэлтэй иргэдийн суурь мэдлэг ур чадвар хэрхэн дээшилж байгаа эсэхийг шалгах механизмыг бүрдүүлж нийт иргэдийн мэдээллийн технологийн суурь мэдлэг ямар түвшинд байснаас ямар түвшинд хүрснийг тоон утгаар илэрхийлбэл зохилтой гэж үзэж байна.

Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын 4.1-т Хүний эрх, эрх чөлөө ангилалд хамаарах 4.1.4-т заасан Ил тод байдал ба хяналт зорилгыг хүрээнд хэрэгжүүлэх 4.1.4.1 дэх буюу “Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлж, төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгох” зорилтын 1062-т туссан “Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх системийг хөгжүүлэн нээлттэй мэдээллийг тогтмол нийтлэх” арга хэмжээний биелэлт хангалттай хэрэгжилттэй байсаар байна. Тодруулбал 2025 онд Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны “Ажил хариуцуулах” 49 дүгээр захирамж, холбогдох албан даалгавруудад үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас “Шилэн индекс”-ийн үнэлгээг хийж гүйцэтгэж байна. Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх “Нээлттэй мэдээллийн систем (www.shilen.gov.mn)”-ийн 2.0 хувилбарыг 2023 онд ашиглалтад нэвтрүүлсэн. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар төсвийн 4,572 байгууллагын 5,113 албан хаагч тус системд хандан ажиллаж, ил тод, нээлттэй байдлын тайлангаа илгээж, хэвшсэн бөгөөд улсын хэмжээнд ил тод, нээлттэй байдлын дундаж үзүүлэлт 69.86%-тай байна. Тухайлбал, Төрийн захиргааны төв байгууллагын дундаж үзүүлэлт 49.4%, төрийн захиргааны байгууллагуудын дундаж үзүүлэлт 78.08%, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дундаж үзүүлэлт 74.9% болон 21 аймгийн Засаг даргын Тамгын газрын дундаж үзүүлэлт 77.09%-тай тус тус үнэлэгээтэйгээр системийн ажиллагаа хэвийн явагдаж байгаа талаар дурдагджээ.

Мөн дээрх бодлогын 4.2 дахь Авлигагүй засаглал ангилалын 4.2.2-т Дэвшилтэт технологид суурилсан цахим засаглал зорилгын 4.2.2.1-т “Төрийн үйлчилгээний шат дамжлагыг цөөн үе шаттай байхаар дахин инженерчлэл хийж, төрийн үйлчилгээг иргэнд шуурхай, чирэгдэлгүй хүргэх” зорилтын 1120-д туссан “Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр хүргэж буй үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх” төсөл арга хэмжээний хэрэгжилт хэвийн явагдаж байна. Тодруулбал “Төрийн үйлчилгээний нэгдсэн системд 2025 оны 12 дугаар сард 1,064 хэрэглэгч шинээр нэмэгдсэнээр нийт бүртгэлтэй хэрэглэгчийн тоо 2,087,342 хүрсэн. 2025 оны 12 сарын эхний 10 хоногийн байдлаар нийт 88 байгууллагын 1268 үйлчилгээг 92 сая удаа үзүүлсэн байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр үзүүлсэн нийт үйлчилгээ нь 1,587,327,899,587 төгрөгийн шууд бус зардлыг хэмнэсэн. Үүнээс 2025 онд 297,454,272,598 төгрөгийн хэмнэлт хийсэн байна” гэжээ. Түүнчлэн Төрийн үйлчилгээний “E-Mongolia 5.0” системийг хөгжүүлэх суурь судалгаа болох “Сингапур, Эстони болон бусад орны төрийн цахим үйлчилгээний чатботуудын хэрэглээ” судалгааг боловсруулж, судалгааны дагуу Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia 5.0 хувилбарыг хөгжүүлж, 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр хэрэглээнд нэвтрүүлсэн нь иргэд үйлчилгээгээ авахад илүү хялбар, хурд сайтай болсныг илтгэж байна.

Түүнчлэн хөтөлбрийн хүрээнд амжилттай хэрэгжиж буй дараах төсөл арга хэмжээнүүд байна. Тухайлбал:

➤ Иргэн, аж ахуйн нэгжээс төрд байгаа мэдээллийг шаардахгүй байх мэдээллийн жагсаалтыг гаргаж, зохицуулалтын орчныг сайжруулан, цахим хэлбэрт шилжүүлэх ажил;

➤ Монгол Улсад хөдөлгөөнт холбооны 5G сүлжээг нэвтрүүлэх;
➤ Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл хэрэгжүүлэх;

➤ Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс байгуулах;
➤ Мэдээллийн технологийн гарааны бизнесийг дэмжих экосистемийг бий болгох, венч сан байгуулах;

➤ Нотариатын үйл ажиллагааг үе шаттай цахимжуулах;
➤ Олон улсын сертификаттай мэргэжилтэн бэлтгэх арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулах;

➤ Хиймэл оюун ухаан, их өгөгдлийн талаар өнөөгийн байдлын суурь судалгаа хийж, холбогдох бодлогын баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлэх;

➤ Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчилж, цаг бүртгэлийн системийг нэвтрүүлж, тоон гарын үсгийг олон улсад ашиглах нөхцөлийг бүрдүүлэх төслийг хэрэгжүүлэх;

➤ Үндэсний хэмжээнд кибер аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх;

➤ Кибер аюулгүй байдлыг хангах мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах арга хэмжээг үе шаттай зохион байгуулах;

➤ Бүх нийтийн кибер аюулгүй байдлыг хангах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх арга хэмжээнүүд амжилттай хэрэгжиж байна.

Энэ мэтчилэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарт хийж хэрэгжүүлж буй иргэдийн амьдралд эерэг нөлөө бүхий олон ажлууд байгаа ч улс орны эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэлтэйгээр хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч хэрэгжилт гарах боломжгүйд хүрсэн цөөнгүй арга хэмжээнүүд байна. Тухайлбал:

- ❖ Орон нутагт шуудангийн илгээмжийн логистикийн дэд төв байгуулах
- ❖ Замын-Үүд боомтод бүрэн автомат шуудан, логистик төвийг байгуулах
- ❖ Мэдээллийн технологийн төрөлжсөн төв байгуулах
- ❖ “ХҮР” мэдээлэл солилцооны системийг шинэчилж тархсан бүтэц шилжүүлэх
- ❖ Сэлгэн ажиллах дата төвийн тоног төхөөрөмжийн нөөцийг бий болгох
- ❖ Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн платформд нэгтгэх
- ❖ Төрөлжсөн мэдээллийн сангийн нэгдсэн бүртгэлийн системийг бий болгож, хэрэглээнд нэвтрүүлэх

❖ Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх

❖ Засгийн газрын тусгай сангуудын санхүүжилт, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг цахимжуулах

- ❖ Сансрын тухай хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх
- ❖ Хиймэл дагуулын газрын станцын дэд бүтцийг байгуулах
- ❖ Үндэсний хиймэл дагуулыг үйлдвэрлэх, хөөргөх, үйл ажиллагаанд нэвтрүүлэх
- ❖ Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг хэрэгжүүлэх
- ❖ Кибер халдлага, зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх системийг хөгжүүлэх

❖ Хамтрагч, түншлэгч талууд болон олон нийтэд мэдээллийг түргэн шуурхай хүргэх, солилцох нөхцөлийг бүрдүүлэх бүх төрлийн системийн уялдааг хангаж хэрэгжүүлэх гэх мэт арга хэмжээг хэрэгжилт санхүүжилт болон бусад шалтгааны улмаас хэрэгжих нөхцөл бүрдээгүй байна.

Иймээс нөхцөл байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтийн хүрээнд цаашид авч хэрэгжүүлэх талаар дараах зөвлөмжийг бэлтгэлээ.

Тав. Цаашид анхаарах зөвлөмж

Хэрэгжилтийн явцыг эрчимжүүлэх, цаг хугацааны төлөвлөлтийг нарийвчлах, хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог бэхжүүлэх нь чухал байна. Үүний зэрэгцээ, анхан шатны бэлтгэл ажил гүйцэтгэлийн үнэлгээнд хангалттай тусгагдаж чадахгүй байгаа тул шат бүрт бодит ахиц, үр нөлөө бий болгох чиглэлээр үр дүнд чиглэсэн арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байх тул дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Бодлогын нэгж болон хэрэгжилтийг зохицуулах газруудад:

1. Төсвөөс шалтгаалах ажлын төлөвлөгөөг гаргахдаа бодит, дүн шинжилгээтэй, баримтад тулгуурласан хэрэгжихүйц байдлаар төлөвлөж байх;
 2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргахдаа харьяа байгууллагуудын нэмэлт мэдээллийг авч тусгаж хэвших;
 3. Нэгжийн албан хаагчид үр дүнд суурилсан бодит нотолгоонд тулгуурласан тайлан бичиж ирүүлэх;
 4. Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх түвшинд нийцүүлэх, биелэлтийг хангах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах;
 5. Төсөв шаардлагатай төсөл арга хэмжээний эрсдлийг тооцож, төсвийн зарцуулалтыг эрт төлөвлөж гүйцэтгэхэд анхаарч ажиллах;
 6. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт он оноор туссан ажлыг тухайн ондоо багтааж хэрэгжүүлэх;
 7. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд голлон үүрэг гүйцэтгэх албан хаагчид өөрсдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хөтөлбөрт туссан арга хэмжээг орхигдуулалгүй төлөвлөх;
 8. Он дамжсан гүйцэтгэлтэй ажлыг цаг хугацааг анхаарч оны эхэнд хийж хэрэгжүүлэхээр тусгах;
 9. Төсвийн төсөөлөлд бодитой хийж хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ тус бүрт анхаарал хандуулж ажиллах;
 10. Тайлан нэгтгэлийг хариуцаж буй албан хаагч удирдлагаар баталгаажуулсан эцсийн тайланг өгч хэвших;
 11. Бодлогын баримт бичгийн тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг харгалзан бичсэн тайлан өгч хэвших;
 12. Цаашид Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийг мөрдлөг болгон Засгийн газрын 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-д заасан хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчийн эрх үүрэгтэй танилцан хамтран ажиллахыг анхаарна уу.
- Жич: Яамны газар, хэлтсийн дарга нар дээрх зөвлөмжүүдийг ил байршуулах бүрт нэгжийн албан хаагчдаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг хийх болохыг үүгээр мэдэгдэж байна.
- Мөн эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрхэн ахиулах болон тайлагнах талаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын албан хаагчдаас зөвлөгөө, дэмжлэг авч ажиллахыг хүсье.